



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дүгнэлтийн дагуу “Мобиком корпораци” ХХК-ийн 21 аймаг болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 23700046 тоот тусгай зөвшөөрлийн хугацааг 10 жилээр сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР